



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөхморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/13/НА-СТА-ТТЗ

|                                                                                  |                                                                                                       |
|----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот2024 он | Дарга,Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа                                                                  |
|                                                                                  | Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a>       |
|                                                                                  | Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг                                                                        |
|                                                                                  | Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> |
|                                                                                  | Ахлах аудитор: М.Атарцэцэг                                                                            |
|                                                                                  | Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetsegm@audit.gov.mn">atartsetsegm@audit.gov.mn</a>   |
|                                                                                  | Аудитор: Б.Мөнхболд                                                                                   |
|                                                                                  | Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a>     |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 136

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөхморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөхморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 19.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн, үйл ажиллагааны орлогыг 4.1 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 1.1 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварыг 83.3 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 1.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нийт 109.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8-д дэх заалт, Хөхморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолын нэг дэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

0702700428

## **Аудитын гол асуудал**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,178.3 сая төгрөг буюу 81.0 хувьтай байна. Энэ нь төлөвлөснөөс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 227.6 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг 42.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 92.5 хувийн биелэлттэй гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 86.3 хувиар дүгнэсэн байна

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



# Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган. төгрөг/

|                                                | Үзүүлэлт                                          | 2022.12.31           | 2023.12.31         |
|------------------------------------------------|---------------------------------------------------|----------------------|--------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                      |                    |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 821,745.6            | 808,899.7          |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 865,153.8            | 933,360.0          |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>1,686,899.4</b>   | <b>1,742,259.7</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 2,350.0              | 103,946.2          |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 1,684,549.4          | 1,638,313.4        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>1,686,899.4</b>   | <b>1,742,259.7</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                      |                    |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,973,184.0          | 1,480,830.0        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,676,651.3          | 1,146,605.1        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>(2,505,692.1)</b> | <b>(46,236.0)</b>  |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -                    | -                  |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>(2,505,692.1)</b> | <b>(46,236.0)</b>  |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                      |                    |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 4,190,241.5          | 1,684,549.4        |
|                                                | Тайлант оны үр дүн                                | (2,505,692.1)        | (46,236.0)         |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,684,549.4</b>   | <b>1,638,313.4</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                      |                    |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 1,942,284.9          | 1,393,501.9        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 1,534,192.0          | 951,310.4          |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>408,092.9</b>     | <b>442,191.5</b>   |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(221,434.2)</b>   | <b>(343,820.0)</b> |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>(75,000.0)</b>    | <b>-</b>           |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>111,658.8</b>     | <b>98,371.5</b>    |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 104,699.3            | 216,358.1          |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 216,358.1            | 314,729.6          |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ, ОНТ</b>     |                                                   |                      |                    |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>1,453,897.4</b>   | <b>1,178,261.0</b> |
|                                                | Урсгал зардал                                     | 887,106.4            | 881,123.0          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | 524,791.0            | 297,138.0          |
|                                                | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл        | 42,000.0             | -                  |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>1,453,897.4</b>   | <b>1,249,845.6</b> |
|                                                | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>             | <b>1,212,218.1</b>   | <b>1,202,032.0</b> |
|                                                | Орон нутгийн төсвөөс                              | 1,212,218.1          | 1,202,032.0        |
|                                                | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих           |                      |                    |
|                                                | <b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>      | <b>241,679.3</b>     | <b>47,813.6</b>    |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                      | 159,081.1          |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |                      | 230,665.6          |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 122.0 мянган төгрөгийн 1 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 130,691.8 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 130,691.8 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн байна. Залруулагдаагүй зөрчлийн дүн 130,691.8 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 27,736.6 мянган төгрөгөөс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 5.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээр үндсэн зээлийг хуваарьт хугацаанд төлүүлээгүй 4,455.5 мянган төгрөгийн 1 зөрчил илрүүлж, уг зөрчилд 4,455.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, төлбөрийн актыг хүргүүлсэн байна.

### 5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 49,627.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 50,174.5 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

## 5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 130,691.8 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 130,691.8 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

### 5.2 Албан шаардлага

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд үйл ажиллагааны орлогын албан татвар 4,120.4 мянган төгрөгөөр, газрын төлбөр 1,068.3 мянган төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 83,278.6 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 1,405.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Хөхморьт Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоол" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг биелүүлэх албан шаардлага хүргүүлсэн.



2.Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 19,448.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,455.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,992.5 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад<br>хамрагдсан<br>байгууллагын нэр      | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй<br>орхигдуулсан |          | Буруу тусган<br>илэрхийлсэн |                 | Үүнээс   |                 | Залруулаагүй |
|------------------------------------------------|------------|-----------------|--------------------------------------|----------|-----------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
|                                                | Тоо        | Дүн             | Тоо                                  | Дүн      | Тоо                         | Дүн             | Тоо      | Дүн             |              |
| Хөхморьт сумын<br>Засаг даргын<br>Тамгын газар | 4          | 49,627.0        |                                      |          | 4                           | 49,627.0        | 4        | 49,627.00       | -            |
| Хөхморьт сумын<br>Хоршоо хөгжүүлэх<br>СБН      | 2          | 3744.9          | -                                    | -        | 2                           | 3744.9          | 2        | 3744.9          | -            |
| <b>Дүн</b>                                     | <b>6</b>   | <b>53,371.9</b> | <b>-</b>                             | <b>-</b> | <b>6</b>                    | <b>53,371.9</b> | <b>6</b> | <b>53,371.9</b> | <b>-</b>     |

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр                | Бүгд     | Өөрчлөлтгүй | Хязгарлагдтай | Сөрөг    | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт  | Нийт алдаа, зөрчлийн дүн |                  | Үүнээс:       |                | Албан шаардлага |                  | Зөвлөмж  |          |
|----------------------------------------------------|----------|-------------|---------------|----------|---------------------------|----------|--------------------------|------------------|---------------|----------------|-----------------|------------------|----------|----------|
|                                                    |          |             |               |          |                           |          | Тоо                      | Дүн              | Төлбөрийн акт |                | Тоо             | Дүн              | Тоо      | Дүн      |
|                                                    |          |             |               |          |                           |          |                          |                  | Тоо           | Дүн            |                 |                  |          |          |
| Хөхморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч        | 1        |             | 1             |          |                           |          | 2                        | 130,691.8        |               |                | 2               | 130,691.8        | -        | -        |
| Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар           | 1        | 1           |               |          |                           |          | 2                        | 14,992.5         |               |                | 2               | 14,992.5         | -        | -        |
| Хөхморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал        | 1        |             |               |          |                           | 1        |                          |                  |               |                |                 |                  | -        | -        |
| Хөхморьт сумын Хоршоо хөгжүүлэх сан                | 1        |             |               |          |                           | 1        | 1                        | 4,455.5          | 1             | 4,455.5        |                 |                  | -        | -        |
| Хөхморьт сумын Орон нутгийн хөгжлийн сан           | 1        |             |               |          |                           | 1        |                          |                  |               |                |                 |                  | -        | -        |
| Хөхморьт сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | 1        |             |               |          |                           | 1        |                          |                  |               |                |                 |                  | -        | -        |
| <b>Дүн</b>                                         | <b>6</b> | <b>1</b>    | <b>1</b>      | <b>0</b> | <b>0</b>                  | <b>4</b> | <b>5</b>                 | <b>150,139.8</b> | <b>1</b>      | <b>4,455.5</b> | <b>4</b>        | <b>145,684.3</b> | <b>-</b> | <b>-</b> |

## 6.3 Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр      | Нийт алдаа, зөрчлийн дүн |                 | Үүнээс:       |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          |
|------------------------------------------|--------------------------|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|----------|
|                                          | Тоо                      | Дүн             | Төлбөрийн акт | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      |
|                                          |                          |                 | Тоо           | Дүн      |                 |                 |          |          |
| Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар | 1                        | 35,182.0        | -             | -        | 1               | 35,182.0        | -        | -        |
| <b>Дүн</b>                               | <b>1</b>                 | <b>35,182.0</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>35,182.0</b> | <b>-</b> | <b>-</b> |